



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

“Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/1016 дугаар захирамж, Газрын дүрмийн 4.1.5, 4.1.8, 7.1.1 дэхь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, хоёр орны аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Бүгд Найрамдах Солонгос Улсаас зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 30-31, 09 дүгээр сарын 01-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 73,260,000 (далан гурван сая хоёр зуун жаран мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.


3. Арга хэмжээг зохион байгуулахад нэгдсэн удирдлагаар ханган ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

79
Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 08 сарын 29 өдрийн
1/2 дугаар тушаалын хавсралт



“СОЛОНГОСЫН СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨДРҮҮД” АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз, хөгжим, лед, карказ, техник түрээсийн зардал	20x5	2,755,000	55,110,000
2	Асар түрээсийн зардал	30ш/3 өдөр 5x5	165,000	14,850,000
3	Цагаан сандал түрээс	220ш/3 өдөр	5000	3,300,000
Нийт дүн				73,260,000